

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН /ДОА-2019/39-ГА/



Хөрөнгө оруулалтын үр нөлөөг бодитой тооцож төлөвлөөгүйгээс тухайн жилд хүрэх зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна.

Чойбалсан хот

2019 он

Агуулга

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймаг дахь Төрийн
аудитын газрын
Гүйцэтгэлийн аудитын
алба

Дарга бөгөөд Тэргүүлэх
аудитор Б.Болортуул
Утас: 70584203

Хэлтсийн дарга бөгөөд
аудитын менежер
В.Цэнгэлмаа
Утас: 70584204

Ахлах аудитор
Б.Дэлгэрмаа,

Аудитор
Я.Зориг
С.Энхбаатар
Утас: 70584207

2019 оны 04 дүгээр сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70584207, 70584204
дугаарын утас болон
dornod@audit.gov.mn
цахим хаягаар
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
аймгийн ЗДТГ-ын 2-р байр,
2 давхар 04 тоот

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

**I Бүлэг. Хөрөнгө оруулалтын төсөл, арга
төлөвлөлт хууль, журмын дагуу үн
хийгдээгүй байна.**

1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
бодлогын хүрээнд төлөвлөөгүй байна.

1.2. Хууль, журамд заасан шаардлагыг ханга
арга хэмжээг төлөвлөсөн байна.

**II Бүлэг. Хөрөнгө оруулалтын төсөл, арга
хэрэгжилт хангалтгүй байна.**

2.1. Аймаг, сумдад тендерийн үнийн санал а
цахим сайтад байршуулаагүй, үнэлгээн
бусад байгууллагын төлөөллийг оролцуула
нийтлэг байна.

2.2. Гүйцэтгэгч компаниуд гэрээний үүргээ х
бүрэн биелүүлээгүй тохиолдлууд гарсан бай

2.3. Эрх шилжүүлсэн арга хэмжээнд за
хяналт хангалтгүй байна.

Б.4. Орон нутгийн төсвийн хөрөнгө
хэрэгжилтэд хийж буй ТЕЗ-ийн дотоод хяна
эцэслэн дуусаагүй байна.

**III Бүлэг. Орон нутгийн хөрөнгө оруу
нөлөөг бодитой тооцож төлөвлөөгүй бай**

3.1. Тухайн жилд хүрэх зорилтот түв
хангагдаагүй байна.

3.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруу
нөлөөг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

ДҮГНЭЛТ**ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН****ЗӨВЛӨМЖ****ТУШААЛ****ТӨЛБӨРИЙН АКТ****АЛБАН ШААРДЛАГА**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ГА	Гүйцэтгэлийн аудит
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУ	Монгол Улс
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ЗГ	Засгийн газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗД	Засаг дарга
ГХБХБГ	Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар
СС	Сангийн сайд
СЯ	Сангийн яам
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХО	Хөрөнгө оруулалт
ЗХ	Зэвсэгт хүчин
ГИХШХГ	Гадаадын иргэний харьяа шилжилт хөдөлгөөний газар
СХАА	Санхүү, хяналт, аудитын алба
БТСХ	Биеийн тамир, спортын газар
СТ	Статистикийн хэлтэс
АТҮТ	Авто тээврийн үндэсний төв
ҮХ	Үнэлгээний хороо
ХАА	Худалдан авах ажиллагаа

ХХҮГ	Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
БОЭТ	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв
ТББ	Төрийн бус байгууллага
ДБЭХС	Дорнод бүсийн эрчим хүчний систем
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг МҮЕА-ын орлогчийн “Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 2019 оны А/03 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасны дагуу Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, нөлөөнд аудит хийж, дүгнэлт өгч, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн байна уу?
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцсон байна уу?

Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, сумдын ЗДТГ хамрагдлаа.

Үндсэн мэдээлэл:

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2,4 тэрбум төгрөгийн 57 төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Сумдад хөрөнгө оруулалтаар 2018 онд 1,5 тэрбум төгрөгийг баталсан байна.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журамд заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх,

тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, бодит байдал дээр оршин байгааг үзэх, ажиглалт хийх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Газрын тухай хууль
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын журам"
- Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер В.Цэнгэлмаа хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор Я.Зориг, С.Энхбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа:

Аудитын талбарын ажлыг 02 дугаар сарын 28-ны өдрөөс эхлүүлэн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд 04 дүгээр сарын 10-ны өдөр хүргүүлээ.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, түүнд өгсөн тайлбар гэсэн хэсгүүдээс бүрдэх бөгөөд аудитын дэд зорилтын дагуу бичлээ. Аудитын тайлангийн төслийг шалгадагч байгууллагын удирдлагад танилцуулж санал авсан бөгөөд тайлангийн эцсийн хувилбарыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дарга бөгөөд Тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажууллаа.

I Бүлэг. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт хууль, журмын дагуу үндэслэлтэй хийгдээгүй байна.

A.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүй байна.

Дорнод аймагт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжүүлэхээр нийт 57 төсөл арга хэмжээ батлагдсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүд нь орон нутгийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан эсэхийг үзэхэд дараах байдалтай байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2018 оны орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдаж, батлагдсан байх ёстой.

Аймгийн 2018 оны хөрөнгө оруулалтад тусгагдсан нийт 57 төсөл арга хэмжээнээс дараах 6 төсөл, арга хэмжээ нь дээрх баримт бичгүүдэд тусгагдаагүй байна. Үүнд:

1. Биеийн тамир, спортын газарт бадминтоны дэвжээ худалдан авах /9,0 сая төгрөг/
2. Хөгжим, техник хэрэгсэл /Хилийн 0132-р анги 6,8 сая төгрөг/
3. Соёл мэдээллийн төвийн багаж, тоног төхөөрөмж /Зэвсэгт хүчний 327-р анги 20,0 сая төгрөг/
4. Аймгийн МХГ-ын Хавирга боомт дахь ажилчдын байр /20,0 сая төгрөг/
5. Авто тээврийн үндэсний төвийн Дорнод аймаг дахь салбарын тавилга, хэрэгсэл /5,0 сая төгрөг/
6. Цагаан-Овоо сумын халуун усны барилгын ажилд дэмжлэг /30,0 сая төгрөг/
7. Сумын эрүүл мэндийн төвийн барилгын тоосгон хаяавчтай төмөр сараалжин хашааг шинээр хийх /Хөлөнбуйр 30,0 сая/
8. Чойбалсан нисэх онгоцны буудлын зочид хүлээн авах танхимын засварт дэмжлэг /20,0 сая/

Сумдын хөрөнгө оруулалтаар 2018 онд 1468,3 сая төгрөгийг баталснаас сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, сумын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй дараах ажлууд байна. Үүнд:

1. Матад сум 8 төсөл, арга хэмжээ /59,7 сая төгрөг/
2. Булган сум 1 төсөл, арга хэмжээ /10,0 сая төгрөг/
3. Хэрлэн сум 3 төсөл, арга хэмжээ /613,0 сая төгрөг/
4. Баян-Уул сум 3 төсөл, арга хэмжээ /11,3 сая төгрөг/
5. Дашбалбар сум 1 төсөл, арга хэмжээ /3,0 сая төгрөг/
6. Халхгол сум 1 төсөл, арга хэмжээ /17,0 сая төгрөг/

Аймаг, сумдын хувьд төсөвт байгууллага болон холбогдох газруудаас ирүүлсэн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналыг хурлаар хэлэлцэж ач холбогдлоор нь эрэмбэлж хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон эсэх нь баримтаар нотлогдохгүй байгаа бөгөөд төлөвлөлтийн талаар судалгаа шинжилгээ хийсэн баримт материал байхгүй байна.

А.2. Хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүд нь нэр, байршил тодорхой, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулагдсан, магадлал хийгдсэн, зохих зөвшөөрлүүд олгогдсон нөхцөлд Төсвийн тухай хууль болон орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын дагуу хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдах ёстой.

2018 оны төлөвлөгөөнд тусгагдсан зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр буруу батлагдсан байна. Үүнд:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал нэрээр батлагдсан гүйцэтгэлийг үзэхэд Чулуунхороот суманд цагдаагийн машин,

2. Чулуунхороот суманд халуун усны байр худалдан авсан төсөл, арга хэмжээ “халуун усны барилга” нэрээр батлагдсан байна.

Хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсвийг боловсруулж, батлуулсан хугацааг үзэхэд Төсвийн тухай хуулийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэсэн заалттай нийцэхгүй байна. Үүнд:

Дорнод аймгийн хэмжээнд 2018 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 57 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсанаас зураг төсөв шаардлагатай 17 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс 6 төсөл, арга хэмжээний зураг, төсөв нь төсөв батлагдсанаас хойш буюу тайлант хугацаанд хийгдэж баталгаажсан байна.

Хүснэгт №1.

№	Төсөл арга хэмжээний нэр	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Зураг төсөв батлагдсан он
1	Нийтийн орон сууцны барилгын дээврийн засвар /Хэрлэн, Халхгол сум/	350,0	2018.04 сар
2	Булган сумын сургуулийн дотуур байрны засвар	40,0	2018.05 сар
3	Матад сумын сургуулийн дотуур байрны засвар	10,0	2018.08 сар
4	Чойбалсан нисэх онгоцны буудлын зочид хүлээн авах танхимын засварт дэмжлэг	28,0	2018.02 сар
5	Халуун усны барилга /Хэрлэн сум, 1-р баг/	65,0	2018.7 сар
6	Баяндун сумын Эмнэлгийн моргийн барилга	15,0	2018
	Дүн	500,0	

Ажлын даалгавар, техникийн тодорхойлолтгүй, тооцоо, судалгаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлуулсан байна.

Үүнд:

1. Баян-Уул сум 13 төсөл, арга хэмжээ /54,7 сая төгрөг/
2. Булган сум 1 төсөл, арга хэмжээ /10,0 сая төгрөг/
3. Дашбалбар сум 6 төсөл, арга хэмжээ /24,5 сая төгрөг/
4. Халхгол сум 7 төсөл, арга хэмжээ /87,0 сая төгрөг/

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Халуун усны барилга /Хэрлэн сум, 1-р баг/ ашиглалтад орсон ч уг ажил нь техникийн нөхцөл аваагүй, аль байгууллага нь хариуцаж ажиллах нь тодорхойгүй, ашиглалтын зардалгүй гэдэг шалтгаанаар үйл ажиллагаа явуулахгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн зураг төсөвт Засгийн газрын 2018 оны 97 дугаар тогтоолын дагуу магадлал хийлгэх шаардлагагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй, тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй хөрөнгө оруулалтуудыг төлөвлөж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Хилийн 0132 дугаар ангид хөгжим, техник хэрэгсэл /6,8 сая төгрөг/
2. ЗХ-ний 0327 дугаар ангид соёл мэдээллийн төвийн багаж тоног төхөөрөмж /20,0 сая төгрөг/

3. Чойбалсан нисэх онгоцны буудлын зочид хүлээн авах танхимын засварт нийт 28,0 сая төгрөг /аймгийн төсвөөс 20,0 сая төгрөг, Хэрлэн сумын төсвөөс 8,0 сая төгрөг/
4. Хэрлэн сум зүүн бүс дэх ГИХШХГ-т ажлын байр худалдан авах /600,0 сая төгрөг/
5. Авто тээврийн үндэсний төвийн Дорнод аймаг дахь салбарын тавилга, хэрэгсэл /5,0 сая төгрөг/
6. Хэрлэн сум зан заншил, ёслол хүндэтгэлийн өргөө байгуулах 1 төсөл, арга хэмжээ /41,9 сая төгрөг/
7. Дашбалбар сум гандангийн дээврийн засвар 1 төсөл, арга хэмжээ /3,0 сая төгрөг/

Аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн төсөлд “Чойбалсан нисэх онгоцны буудлын зочид хүлээн авах танхимын засварт дэмжлэг” /20,0 сая төгрөг/ төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн дээрх хуулийг зөрчсөн байна гэж үзээд хасах саналыг оруулсан боловч хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 4.1.24 дэх “хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” ХЭЛНЭ гэсэн заалтуудтай нийцэхгүй хөрөнгө оруулалтын бус зардлыг төлөвлөж баталсан байна.

1. Баян-Уул сум урсгал засварт 5 төсөл, арга хэмжээ /14,8 сая төгрөг/
2. Чойбалсан сум сургуулийн кабинет тохижуулах, хичээлийн хэрэглэгдэхүүн авахад 1 төсөл, арга хэмжээ /4,5 сая төгрөг/
3. Дашбалбар сум урсгал засварт 3 төсөл, арга хэмжээ /10,0 сая төгрөг/
4. Сэргэлэн сум төрийн албан хаагчдын мэдлэг, чадвар дээшлүүлэх сургалтын зардал 1 төсөл, арга хэмжээ /2,5 сая төгрөг/
5. Статистикийн хэлтсийн автомашин засвар /2,8 сая төгрөг/

II Бүлэг. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

Б.1. Аймаг, сумдад тендерийн үнийн санал авах урилгыг цахим сайтад байршуулаагүй, үнэлгээний хороонд бусад байгууллагын төлөөллийг оролцуулаагүй зөрчил нийтлэг байна.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудад тендерийн үнэлгээний хороог хууль, журмын дагуу зохион байгуулаагүй 886,8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ТАХ байна. Тухайлбал:

- “Нийтийн орон сууцны барилгын дээврийн засвар /Хэрлэн, Халхгол сум - 510,0 сая төгрөг/, ҮХ-ний 1 гишүүний ХАА-ны АЗ-ын хугацаа дууссан.
- “Зүүн бүсийн ахмад настны асрамж үйлчилгээний төвийн шинэ барилгын ажлыг зураг төсвийн дагуу хийж дуусгана. /72,6 сая төгрөг/, ҮХ-ний 5 гишүүн АЗ сертификатгүй, гишүүдэд бусад байгууллагын төлөөлөл байхгүй.
- “1 ба 3 фазын цахилгаан тоолуур шалгаж баталгаажуулах эталон төхөөрөмж болон 50-100 голчтой усны тоолуур шалгах багажийн нэмэлт тоног төхөөрөмжөөр хангах. /18,0 сая төгрөг/, ҮХ-ний 3 гишүүн АЗ сертификатгүй, гишүүдэд бусад байгууллагын төлөөлөл байхгүй.
- “Аврагчийн гараас амьдрал цэцэглэнэ хөшөөнд дэмжлэг /15,0 сая төгрөг/, ҮХ-ний 5 гишүүнээс 2 нь АЗ сертификатгүй, гишүүдэд бусад байгууллагын төлөөлөл байхгүй.
- “Матад сумын сургуулийн дотуур байрны засвар /10,0 сая төгрөг/, ҮХ-ний гишүүдэд бусад байгууллагын төлөөлөл байхгүй.
- “Сэргэлэн сумын соёлын төвийн барилгын дээврийн засвар /37,0 сая төгрөг/, ҮХ-ний 7 гишүүний 5 нь АЗ сертификатгүй, гишүүдэд бусад байгууллагын төлөөлөл байхгүй.
- “Сумын эрүүл мэндийн төвийг боловсон ариун цэврийн байгууламжтай болгох /Чулуунхороот сум - 22,3 сая төгрөг/, ҮХ-ний 5 гишүүний 4 нь АЗ сертификатгүй, гишүүдэд бусад байгууллагын төлөөлөл байхгүй.
- “Орон нутаг судлах кабинет байгуулах /Баян-Уул сум 25,0 сая төгрөг/, ҮХ-ний 5 гишүүний 2 нь АЗ сертификатгүй, гишүүдэд бусад байгууллагын төлөөлөл байхгүй.
- ““Гэрэл сэтгэмж” ОНӨҮГ-ын машин тоног төхөөрөмж /50,0 сая төгрөг/, ҮХ-ний 3

- гишүүн АЗ сертификатгүй, гишүүдэд бусад байгууллагын төлөөлөл байхгүй.
- “Орон нутгийн өмчит төрийн байгууллагуудын автомашины парк шинэчлэл /аймгийн БОАЖГ 35,0 сая төгрөг/, ҮХ-ний 7 гишүүний 3 нь АЗ сертификатгүй, гишүүдэд бусад байгууллагын төлөөлөл байхгүй.
- “Дашбалбар сумын ЗДТГ-т суудлын авто машин авахад дэмжлэг /25,0 сая төгрөг/, ҮХ-ний 5 гишүүний 3 нь АЗ сертификатгүй, гишүүдэд бусад байгууллагын төлөөлөл байхгүй.
- “Хэрлэн сумын Хан-Уул лаборатор цогцолбор сургуулийн завсар /28,9 сая төгрөг/, ҮХ-ний 6 гишүүний 3 нь АЗ сертификатгүй, ҮХ-г журмын дагуу сондгой тоогоор байгуулаагүй.
- “Аймгийн МХГ-ын Хавирга боомт дахь ажилчдын байр /20,0 сая төгрөг/, ҮХ-ний 6 гишүүд нь АЗ сертификатгүй, гишүүдэд бусад байгууллагын төлөөлөл байхгүй, ҮХ-г журмын дагуу сондгой тоогоор байгуулаагүй.

Үнэлгээний хороог худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн хүнээр бүрдүүлээгүй, бусад байгууллагын төлөөллийг оролцуулаагүй, гишүүдийн тоог сондгой тоогоор зохион байгуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.4¹, 47.6², Сангийн сайдын 2007 оны 81 дүгээр тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 2.1³ дэх заалтуудтай нийцэхгүй байна.

Тендерийн үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг тооцоо, судалгаагүй боловсруулснаас техникийн тодорхойлолтоос зөрүүтэй нийлүүлэгдсэн 35,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээ байна.

- “Сумдын ЗДТГ-ын автомашины парк шинэчлэл /Хөлөнбуйр 35,0 сая төгрөг/, техникийн тодорхойлолтод нийцэхгүй худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргаас холбогдох газар, хэлтэс, суманд эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагаа хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй /тендерийн үнийн санал авах урилгыг www.tender.gov.mn сайтад байршуулж, ил тод, нээлттэй мэдээлээгүй, үнэлгээний хорооны шийдвэргүйгээр шууд гэрээ байгуулсан/ 319,9 сая төгрөгийн өртөгтэй 8 ТАХ байна. Тухайлбал:

- “Зүүн бүсийн ахмад настны асрамж үйлчилгээний төвийн шинэ барилгын ажил /72,6 сая төгрөг/, www.tender.gov.mn сайтад үнийн санал авах урилга байршуулаагүй, захиалагч нь ХХҮГ.
- “Сумын эрүүл мэндийн төвийг боловсон ариун цэврийн байгууламжтай болгох /Чулуунхороот сум 22,3 сая төгрөг/, www.tender.gov.mn сайтад үнийн санал авах урилга байршуулаагүй, захиалагч нь тус сумын Эрүүл мэндийн төв.
- “Орон нутаг судлах кабинет байгуулах /Баян-Уул сум 25,0 сая төгрөг/, www.tender.gov.mn сайтад үнийн санал авах урилга байршуулаагүй, захиалагч нь Баян-Уул сумын ЗДТГ.
- Сумдын ЗДТГ-ын автомашины парк шинэчлэл /Чулуунхороот, Булган 70,0 сая төгрөг/, www.tender.gov.mn сайтад үнийн санал авах урилга байршуулаагүй, захиалагч нь Чулуунхороот, Булган сумын ЗДТГ.
- “Гэрэл сэтгэмж” ОНӨҮГ-ын машин тоног төхөөрөмж /50,0 сая төгрөг/, www.tender.gov.mn сайтад үнийн санал авах урилга байршуулаагүй, захиалагч нь “Гэрэл сэтгэмж” ОНӨҮГ.
- “Дашбалбар сумын ЗДТГ-т суудлын авто машин авахад дэмжлэг /25,0 сая төгрөг/,”

¹ 47.4. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутаг тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

² 47.6. Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна.

³ 2.1. Үнэлгээний хороо нь гурав ба түүнээс дээш сондгой тооны гишүүдтэй байх бөгөөд захиалагч тэдгээрийн дундаас үнэлгээний хорооны дарга, нарийн бичгийн даргыг сонгож томилно. Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нь тухайн байгууллагын худалдан авалт хариуцсан мэргэжилтэн байвал зохино.

www.tender.gov.mn сайтад үнийн санал авах урилга байршуулаагүй, захиалагч нь тус сумын ЗДТГ.

- “Аймгийн МХГ-ын Хавирга боомт дахь ажилчдын байр /20,0 сая төгрөг/”, www.tender.gov.mn сайтад үнийн санал авах урилга байршуулаагүй, захиалагч нь аймгийн МХГ.
- “Орон нутгийн өмчит төрийн байгууллагуудын автомашины парк шинэчлэл /аймгийн СХААлба 35,0 сая төгрөг/”, захиалагч нь аймгийн СХААлба. Үнэлгээний хорооны шийдвэрээр тендерт оролцсон 3 компанийг тендерийн баримт бичгийн шаардлага хангаагүй гэсэн шийдвэр гаргаж, шаардлага хангасан өөр компанитай гэрээ байгуулахыг мэдэгдсэн ч шаардлага хангаагүй 3 компанийн 1 болох “Өвөг бадрах” ХХК-тай худалдан авах гэрээ байгуулсан.

Сумдад тендерийн үнийн санал авах урилгыг www.tender.gov.mn сайтад байршуулаагүй нийтлэг зөрчил илэрч байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг дараах байдлаар зохион байгуулсан байна.

Дүрслэл №1



Жич: Зарим ажлууд багц болон задарсан байна.

Үнэлгээний хороод нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийг зохион байгуулахдаа 1 нээлттэй тендерийг 3 удаа зарласан боловч оролцогч ирээгүй, 18 тендерийг харьцуулалтын аргаар тендер зохион байгуулсан ч оролцогч ирээгүй шалтгаанаар шууд худалдан авалт хийсэн байна. Харьцуулалтын аргаар зохион байгуулагдсан тендерийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу тендерийг бага үнийн саналаар шалгаруулах, харьцуулалт амжилтгүй болсон үндэслэлээр шууд худалдан авалт хийх нь бага төсөвт өртгөөр чанаргүй ажил гүйцэтгэгдэх эрсдэлийг үүсгэж байна. Иймд аймгийн Орон нутгийн өмчийн газар нь чиг үүргийн дагуу тендерийн үнэлгээний хороодод тендерийг хэрхэн ил тод, нээлттэй байдлаар зохион байгуулах талаар мэргэжил арга зүйн, зөвлөгөөг өгч ажиллах шаардлагатай байна.

Мөн төсвийн 1 жилд хэт олон ажлыг нэг компаниар гүйцэтгүүлснээс тухайн ажилд ажиллах хүч, техник хэрэгсэл хүрэлцэхгүй байх, гэрээний хугацаанд тухайн ажлыг гүйцэтгэх боломжгүй болох зэрэг сөрөг үр дагавартай байна. Тухайлбал хамгийн олон ажил авсан “Бүжнэр” ХХК нь 2018 онд аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр 6, “Авто агро” ХХК 5, “Мед буян” ХХК 4 ажлыг тус тус гүйцэтгэсэн байна.

Цаашид тендерийн үнэлгээний хороод нь тендерт оролцогчдын ажиллах хүч, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, ажлын туршлага, тухайн ажлыг гүйцэтгэх чадвар зэргийг харгалзан үзэж, шалгаруулалтын үйл явцад захиалагч байгууллагын саналыг авах, тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд захиалагч байгууллагаас зайлшгүй оролцуулж байх талаар анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Б.2. Гүйцэтгэгч компаниуд гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй тохиолдлууд гарсан байна.

Бид аудитын явцад аймгийн болон сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээнүүдэд захиалагч, зохиогчийн хяналтаар өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байдал, чанарын байдлын талаар газар дээр нь үзэж танилцсан бөгөөд зөрчилтэй болон ашиглагч байгууллагын зүгээс санал, гомдолтой 122,6 сая төгрөгийн өртөгтэй 2 ТАХ байна. Тухайлбал:

- “Цагаан-Овоо сумын халуун усны барилгын ажилд дэмжлэг /72,6 сая төгрөг/, “Бүжнар” ХХК-ийн гүйцэтгэсэн ажилд ашиглагч байгууллагын зүгээс тус ажлыг чанаргүй гүйцэтгэсэн талаар гомдол ирүүлсэн. Газар дээр нь үзэж шалгахад ашиглалтын явцад барилгын хананд бага зэргийн ан цав үүсэж, ханын будаг, угаалтуур хууларсан байдалтай байна. Гүйцэтгэгч байгууллагын зүгээс төсөвт багтаагүй ажлуудыг хийж гүйцэтгэж, ашиглагч байгууллагын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан хагарч, хөлдсөн халаалтын тогоог сольж, шугамыг засварлан ашиглалтад оруулсан талаар нотлох баримтыг ирүүлсэн болно.
- “Багш хөгжлийн төв” байгуулах. /Баян-Уул, Сэргэлэн, Булган, Баянтүмэн, Дашбалбар, Хэрлэн сумын Хан-Уул сургууль 50,0 сая төгрөг/, “Гантэлмэн” ХХК-иас Сэргэлэн, Баянтүмэн суманд нийлүүлсэн тавилга, эд хогшил нь эвдрэл гэмтэлтэй, хаягжуулалт дутуу нийлүүлэгдсэн байна.

Гэрээний хугацаанаас хэтэрч хүлээлгэж өгсөн 115,0 сая төгрөгийн өртөгтэй 3 ТАХ байна. Үүнд:

- “Матад сумын сургуулийн дотуур байрны засвар /10,0 сая төгрөг/, “Бүжнар” ХХК”, 20 хоног
- “Аймгийн МХГ-н Хавирга боомт дахь ажилчдын байр /20,0 сая төгрөг/, “Дика” ХХК”, 13 хоног
- “БОЭТ-д тархины оношлогооны аппарат /85,0 сая төгрөг/, “Сүвэн-Уул” ХХК”, 10 хоног тус тус гэрээний хугацаанаас хэтрүүлэн гүйцэтгэж, хүлээлгэж өгсөн байна.

Захиалагч байгууллага болох Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, зураг, төсөв зохиогчид, Мэргэжлийн хяналтын газар, хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэгч “Инженер зохион бүтээгчдийн нэгдсэн холбоо” ТББ-ын хяналтаар өгсөн үүрэг даалгаврыг тухай бүрд нь өгч ажилласнаар барилга, барилгын засварын ажлын гүйцэтгэлд гарсан зөрчил дутагдлыг арилгаж ажилласан байна.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан ч ашиглалтгүй байгаа дараах арга хэмжээ байна. Үүнд:

- “Халуун усны барилга /Хэрлэн сум, 1-р баг/, “ДОБЧ” ХХК, “ДБЭХС” ТӨХК-иас техникийн нөхцөл аваагүй байхад барилгыг барьж дуусгасан, ашиглалтгүй байна.

Цаашид дээрх ашиглалт хангалтгүй байгаа Хэрлэн сумын 1-р багийн халуун усны барилгын ашиглагч байгууллагыг тодорхой болгож, цаашид байнгын ажиллагаатай болгох талаар анхаарч үзэх шаардлагатай байна.

Б.3. Эрх шилжүүлсэн арга хэмжээнд захиалагчийн хяналт хангалтгүй байна.

Захиалагчийн хяналтыг орон нутагт аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар хэрэгжүүлж ажилласан байна. Аймгийн ЗДТГ-аас захиалагчийн хяналтын зардалд 14,7 сая төгрөгийг зарцуулж, үүнээс 9,7 сая төгрөгийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, 0,3 сая төгрөгийг хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэгч “Инженер зохион бүтээгчдийн нэгдсэн холбоо” ТББ-д, 4,7 сая

төгрөгийг авто замын хяналтыг хэрэгжүүлэгч мэргэшсэн инженерийн цалингийн зардлыг олгосон байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь захиалагчийн хяналтын зардлыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дансанд төвлөрүүлж ажилласан байна.

Аймгийн Засаг даргаас эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 26 төсөл, арга хэмжээнд тухайн ажлын эрхийг шилжүүлэн авсан байгууллагын захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн талаар ажлын тайланг баримтаар баталгаажуулсан эсэх нь тодорхойгүй байна.

Мөн сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудад ИТХ болон захиалагчийн дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй нийтлэг зөрчлүүд илэрч байна. Хэрлэн, Баян-Уул сумдаас бусад сумдад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн тухай нотлох баримт байхгүй, ИТХ-аас тавих хөндлөнгийн хяналт бүх сумдад хэрэгжээгүй байна.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 1705,8 сая төгрөг олгохоос 1638,9 сая төгрөгийг гүйцэтгэгч байгууллагад олгож, 66,8 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож байгаа хэдий ч худалдан авах ажиллагааны үр дүнгийн биелэлтийг холбогдох цахим систем /www.tender.gov.mn/-д оруулсан талаарх мэдээллийг гүйцэтгэл, санхүүжилтийн баримтад хавсаргаж, баримтжуулаагүй нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.5.3⁴ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна. Бусад бүрдүүлбэрийг гүйцэтгэл, санхүүжилтийн баримтад бүрэн тусгасан байна.

Сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн ажлуудад гүйцэтгэл гараагүй байхад санхүүжилт олгосон, төрийн чиг үүрэгт хамаарахгүй, тухайн шатны захирагч нь өөрийн бүрэн эрхэд хамаарахгүй ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлэн санхүүжилт олгосон 82,5 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- Халхгол сумын Засаг даргын Тамгын газар нь 2018 онд автомашин, цахим худгийн тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, журмыг баримтлаагүй, үнэлгээний хороо байгуулаагүй, гэрээ байгуулаагүй үед 32,0 сая төгрөгийг шилжүүлсэн, хөрөнгийг одоог хүртэл хүлээн аваагүй, мөн гэрээний нөхцөлүүд стандартын шаардлагыг хангахгүй байна.
- Хэрлэн сум Засаг даргын Тамгын газар нь сумын хөрөнгө оруулалтын зардлаас тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй “Зан заншил, ёслол хүндэтгэлийн өргөө байгуулах” засварын зардалд 41,9 төгрөгийг “Данриг данжаалан хийд” ТББ-ын үйл ажиллагааны дэмжлэгт зарцуулсан байна.
- Дашбалбар сумын Засаг даргын Тамгын газар нь хөрөнгө оруулалтын зардлаас тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй, хөрөнгө оруулалтын бус шинжтэй гандангийн дээврийн засварын ажилд 3,0 төгрөгийг зарцуулсан байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 4.1.24, 6.4.2, 6.6.6, 41.2.6, 58,4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан

⁴ 4.5. шаардлагуудыг хангаж, байгаа эсэхийг дараах материалыг үндэслэн ажлын 2 хоногийн дотор санхүүжүүлнэ. Үүнд: 4.5.3. Худалдан авах ажиллагааны үр дүнгийн биелэлтийг холбогдох цахим систем /tender.gov.mn/-д оруулсныг нотлох мэдээлэл

авах тухай хуулийн 40 дүгээр зүйл, Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалын холбогдох зүйл, заалтыг зөрчсөн тул Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12⁵-т заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

- Матад сумын Засаг даргын Тамгын газрын “Таны жолоо” ХХК-тай байгуулсан гэрээ нь гэрээний ерөнхий нөхцөлийг хангаагүй, тавилга, эд хогшил, бараа материал хүлээж аваагүй байхад 5,6 сая төгрөгийг шилжүүлсэн байсан боловч аудитын явцад тавилга, эд хогшлыг авч хүлээн авсан комиссын акт, комиссыг байгуулсан тушаал, фото зургаар албажуулсан баримтуудыг ирүүлж мөн тайлангийн хэлэлцүүлэгт удирдлагаас нь оролцсон. Иймд алдаа зөрчлийг дахин гаргахгүй ажиллах зөвлөмжийг өглөө.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гэрээний хугацаанаас хэтрүүлж, тухайн захиалагч байгууллагад бараа, ажлыг хүлээлгэн өгсөн “Бүжнар” ХХК-иас 20 хоногийн 99,8 мянган төгрөг, “Дика” ХХК-иас 13 хоногийн 130,0 мянган төгрөг, “Сүвэн-Уул” ХХК-иас 10 хоногийн 422,0 мянган төгрөгийн алдангийн төлбөрийг суутган тооцож ажилласан байна.

Сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гэрээний хугацаанаас хэтрүүлэн хүлээлгэн өгсөн ажил гараагүй байна.

Б.4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хийж буй ТЕЗ-ийн дотоод хяналт шалгалт эцэслэн дуусаагүй байна.

Хөрөнгө оруулалтын үйл явцад ТЕЗ-ын дотоод хяналт нь Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.”, ЗГ-ын 2015 оны 483 дугаар тогтоолын 5.2.4-д “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих” гэсэн заалтуудаар тус тус зохицуулагдаж байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2018 оны ажлын төлөвлөгөөндөө 11 дүгээр сарын 25-наас ажлын 30 хоногт буюу 2019 оны 01 дүгээр сарын 04-ны дотор багтаан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хяналт шалгалтыг хийхээр ТЕЗ-аар батлуулсан боловч уг хяналт шалгалтын ажлыг хийх хугацаа нь дууссан байхад 2018 оны ажлыг одоог болтол дуусгаагүй байна. Харин сумдын ИТХ нь 2018 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналтыг хийгээгүй байна.

III Бүлэг. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

В.1. Тухайн жилд хүрэх зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдээс зорилтот түвшин бүрэн хангагдаагүй, ашиглагдахгүй дараах ажлууд байна.Үүнд:

- Цагаан-Овоо сумын халуун усны барилгын ажлыг “Бүжнар” ХХК хийсэн боловч тус барилгын тогоо хөлдсөн, ус халаагч төхөөрөмж нь ажиллахгүй, 5 боллер ашиглахаас 2-ыг ашиглаж байна. Бүрэн хүчин чадлаар

⁵ “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”,

ашиглавал цахилгааны дэд станц шаардлагатай гэсэн тайлбарыг ашиглагч талаас өгсөн. Мөн барилгын гаднах доод тал цуурсан, дотор талын ханын будаг хуурсан, дулаан алдалттай хүйтэн байна. Барилгын засварын ажлыг анх төлөвлөхдөө техникийн нөхцөл хийгдээгүй, зураг төсвөө урьдчилж батлуулаагүй, хуульд заасан бусад зөвшөөрөл аваагүй, чанаргүй хийсэн байна. Гэтэл гүйцэтгэгч Бүжнэр ХХК-аас халаалтын тогоо хагарсан нь тухайн үед тус барилгыг хариуцан ажиллаж байсан ОНӨААТҮГ-ын албан хаагчийн хариуцлагагүй байдлаас болсон. Техникийн нөхцөл нь 3 шүршүүр боломжтой байдлаар өгөгдсөн байсан. Барилгын тогоо хөлдөөсөн паар, зуухыг засах арга хэмжээ авч бүрэн ашиглалтад оруулсан. Будгийн ажлыг сумын ОНӨААТҮГ хариуцаж хийхээр болсон гэсэн тайлбарыг гүйцэтгэгч компаниас өгсөн.

- Халуун усны барилга /Хэрлэн сумын 1-р баг/-ын ажлыг “ДОБЧ” ХХК хийсэн боловч тус барилгын ажил анх төлөвлөгдөхдөө техникийн нөхцөл хийгдээгүй, зураг төсвөө урьдчилж батлуулаагүй, мэргэжлийн байгууллагаас холбогдох зөвшөөрөл олгогдоогүйн улмаас ашиглалтгүй байна.
- Өрхийн эрүүл мэндийн төвд 16,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнээс 2.0 сая төгрөгийн УВЧ аппаратанд доголдол гарсны улмаас ашиглагдахгүй байна. /Ягаан цээнэ/

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдээс зорилтот түвшин хангагдаагүй, ашиглагдахгүй дараах ажлууд байна. Үүнд:

Дашбалбар сум:

- Цагдаагийн хэсэг /кубон/-ийн халаалтын тогоог засварлах 3,0 сая төгрөгийн ажил хийгдсэн боловч дотор шугам нь гэмтэлтэй, дахиж засвар хийх шаардлагатай байгаагаас шалтгаалж ашиглалтгүй байна. Мөн анх төлөвлөхдөө хуульд заасан холбогдох шаардлагуудыг хангаагүй байхад засварын ажлыг хийсэн байна.

Хэрлэн сум:

- Сумын ЗДТГ-ын дулаан цэвэр, бохир шугамын засварт /материалын үнэ/ 34,6 сая төгрөгийн материал худалдан авч хийгдэх ёстой боловч тус материалыг нийлүүлэх ажлын тендерт шалгарсан компани нь гэрээ байгуулахаас татгалзсан тул Хос өргөө ХХК-тай шууд гэрээ байгуулсан байна. Засварын ажлын материалыг “Хос өргөө” ХХК нь гэрээний дагуу 12 сард нийлүүлснээс шалтгаалж, ДБЭХС ТӨХК-иар 2019 онд хийлгэхээр болсон байна.
- Хотын зам дагуух хогийн савны тоог нэмэгдүүлэхээр худалдан авсан 70 ширхэг хогийн савнаас 40 ширхэгийг байрлуулаагүй байна. Байрлуулаагүй байгаа 40 ширхэг хогийн савыг байрлуулж болох байсан боловч аймгийн төвийн хойд төв зам дагуу шинэ замын ажил хийгдэхээр зураг төсөв нь улсын төсөвт батлагдсан тул хогийн савыг байрлуулсан тохиолдолд эргүүлж авч дахин байрлуулах шаардлага үүсэх учраас байрлуулаагүй байна.

Чойбалсан сум:

- Сумын ЗДТГ-ын албан хаагчдад олгосон 928,0 мянган төгрөгийн 1 ширхэг компьютер эвдэрсний улмаас ашиглалтгүй байна.

В.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 29.2-т “Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.”, 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.” гэсэн заалтуудын дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр ашиг, үр өгөөжийг тооцсоны үндсэн дээр төсвийн төлөвлөлтөд тусгах ёстой.

Аудитын явцад орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдэд үр ашиг, үр өгөөжийг тооцоолсон эсэхэд горим сорилыг хэрэгжүүлэхэд эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, чанарын ахиц дэвшлийг хэмжигдэхүйц байдлаар, тоон үзүүлэлтээр нарийвчлан тооцоолж төлөвлөсөн судалгаа, тайлан, мэдээлэл байхгүй байна.

Өмнөх 2017 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар аймгийн хэтийн зорилт бодлогын баримт бичигт тусгагдсан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөхдөө холбогдох хуульд заасан шаардлагуудыг хангах зөвлөмжийг өгсөн байхад орон нутгийн 2018 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөхдөө эдийн засгийн үр ашиг, үр өгөөжийг нарийвчлан тооцоогүй нь ашиглалтад хүлээж авсан 168,8 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ нь бүрэн ашиглалтгүй байгаагаас харагдаж байна.

Орон нутгийн төсвөөр төрийн өмчит байгууллагын 704,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 4.1.24-т “хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”, 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалтуудын шаардлагыг хангахгүй байна.

Тайлант онд хэрэгжиж дуусахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүд бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд төсөвт өртөгт өөрчлөлт ороогүй байна.

Өмнөх оны “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар хөрөнгө оруулалтын үр ашиг, үр өгөөжийг дээшлүүлж ашиглалтыг сайжруулах талаар зөвлөмж өгсөн ч 2018 онд шинээр хэрэгжсэн 168,8 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ мөн ашиглагдахгүй байгаа нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт хууль, журмын дагуу үндэслэлтэй хийгдээгүй байна.
2. Аймаг, сумдад тендерийн үнийн санал авах урилгыг цахим сайтад

- байршуулаагүй, үнэлгээний хороонд бусад байгууллагын төлөөллийг оролцуулаагүй зөрчил нийтлэг байна.
3. Гүйцэтгэгч компаниуд гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй тохиолдлууд гарсан байна.
 4. Эрх шилжүүлсэн арга хэмжээнд захиалагчийн хяналт хангалтгүй байна.
 5. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хийж буй ТЕЗ-ын дотоод хяналт эцэслэн дуусаагүй байна.
 6. Хөрөнгө оруулалтын үр нөлөөг бодитой тооцож төлөвлөөгүйгээс тухайн жилд хүрэх зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна.
 7. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, зөрчил давтагдан гарсан байна.

Аудитаар нийт 3552,1 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн 76,9 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 842,6 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, 2632,6 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгч ажиллалаа.



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Утас: 7098-4202, Факс: 7098-4284

2019-04-08 № 4684

талай -нм № -т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Гүйцэтгэлийн аудитын тайланд
хариу хүргүүлэх тухай

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2018 онд Дорнод аймагт хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, дүгнэлттэй танилцаж дараах тайлбар, хариуг хүргүүлж байна.

- Хэрлэн сумын 1 дүгээр багийн халуун усны барилгыг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын эзэмшилд шилжүүлсэн бөгөөд даруй ашиглалтад оруулах талаар Хэрлэн сумын Засаг даргад чиглэл өгч ажиллах болно.
- Аймгийн төсвийн хөрөнгөөр Хилийн 0132 дугаар анги болон Зэвсэгт хүчний 327 дугаар ангиудын соёл, мэдээллийн төвд худалдан авсан хөгжим, техник, тоног төхөөрөмжийг аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгийн орлогод бүртгэн авч тус ангиудтай ашиглалтын гэрээ байгуулан түр ашиглуулах болно.
- Аймгийн иргэлийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 7 дугаар хуралдааны 13 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн 2018 оны төсөвт хийгдсэн нэмэлт өөрчлөлтийг Сангийн яамнаас 2018 оны 08 дугаар сард тодотголын төсөв татаж, гүйлгээ хийх эрхийг нээсэнтэй холбоотой төсөл, арга хэмжээний шинж чанар, цар хүрээ, төсөвт өртгийг харгалзан 9 төсөл, арга хэмжээг холбогдох төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагч нарт эрх шилжүүлэх замаар зохион байгуулж хэрэгжүүлэн ажилласан билээ. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.2-т заасан босго үнээс бага өртөгтэй буюу 10.0 сая төгрөгөөс бага төсөвтэй тендер зарлахгүйгээр шууд худалдан авах 6 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Дорнод аймагт 2018 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, дүгнэлтийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА М.БАДАМСҮРЭН



010519411

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн-д

1. СС-ын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3.1, 3.2 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.
2. Худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТ-ийн 47.4, 47.6, Сангийн сайдын 2007 оны 81 дүгээр тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 2.15 дахь заалтыг баримтлан ажиллах.
3. Үнэлгээний хороод нь тендерт оролцогчдын ажиллах хүч, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, ажлын туршлага, тухайн ажлыг гүйцэтгэх чадвар зэргийг харгалзан үзэж, шалгаруулалтын үйл явцад захиалагч байгууллагын саналыг авах, тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд захиалагч байгууллагаас заавал оролцуулж байх.
4. Гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн тохиолдолд хариуцлага тооцох арга хэмжээг тогтмолжуулах.
5. Барилга ашиглалтгүй, ашиглалт хангалтгүй, ашиглагч байгууллага тодорхойгүй байгаа барилгуудад мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулж, цаашид ашиглалтад оруулах талаар холбогдох байгууллагуудад хугацаатай үүрэг чиглэл өгч ажиллах.
6. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хийж буй дотоод хяналт шалгалтыг эцэслэн дуусгаж үр дүнг танилцуулах.

Аудитаар тавигдсан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2019 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 11

Нарийн бичиг 107

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар тавигдсан төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Дэлгэрмаад даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

110219017

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын 2019 оны 04 дүгээр
сарын 10-ны өдрийн 11/тоот тушаалын хясаалт №02

Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Албан шаардлагын утга	Мөнгөн дүн
1	Баяндун сумын ЗДТГ	ДОА-2019/39-ГА	Тооллогоор дутагдсан хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх тухай.	110,000
2	Баян-Уул сумын ЗДТГ	ДОА-2019/39-ГА	Хөрөнгө оруулалтын зардлаас урсгал зардалд зарцуулсан, мөн ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, төсөв тооцоогүй төсөд, арга хэмжээг төлөвлөн батлуулсан.	71,000,000
3	Дашбалбар сумын ЗДТГ	ДОА-2019/39-ГА	Хөрөнгө оруулалтын бус шинжтэй зардлыг санхүүжүүлсэн.	10,000,000
4	Чойбалсан сумын ЗДТГ	ДОА-2019/39-ГА	Хөрөнгийг ашиглалтад оруулах.	928,000
5	Чойбалсан сумын ЗДТГ	ДОА-2019/39-ГА	Хөрөнгө оруулалтын бус шинжтэй зардлыг санхүүжүүлсэн.	4,500,000
6	Сэргэлэн сумын ЗДТГ	ДОА-2019/39-ГА	Хөрөнгө оруулалтын бус шинжтэй зардлыг санхүүжүүлсэн.	1,250,000
7	Аймгийн ЗДТГ	ДОА-2019/39-ГА	Тухайн шатны төсвийн чиг үүрэгт хамаарахгүй үйл ажиллагаанд зарцуулсан, өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	754,800,000
8	Аймгийн ЗДТГ	ДОА-2019/39-ГА	Хариуцлага тооцуулах тухай	-
Нийт дүн				842,588,000.0

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын 2019 оны 04 дүгээр
сарын 10-ны өдрийн /10/ тоот тушаалын хавсралт №01

Төлбөрийн актны жагсаалт

№	Байгууллагын нэр	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Төлбөрийн актны утга	Мөнгөн дүн
1	Халхгол сумын ЗДТГ	ДОА-2019/39-ГА	Хөрөнгийг хүлээж аваагүй, гүйцэтгэл гараагүй байхад санхүүжилт олгосон.	32,000,000
2	Дашбалбар сумын ЗДТГ	ДОА-2019/39-ГА	Тухайн шатны төсвийн чиг үүрэгт хамаарахгүй үйл ажиллагаанд зарцуулсан.	3,000,000
3	Хэрлэн сумын ЗДТГ	ДОА-2019/39-ГА	Тухайн шатны төсвийн чиг үүрэгт хамаарахгүй үйл ажиллагаанд зарцуулсан.	41,969,054
Нийт дүн				76,969,054.00